



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь салбар  
Анагаах ухааны сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/161/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Дорноговь аймаг

2020 он

Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал  
**Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын захирал  
бөгөөд тэргүүлэх аудитор Ч.Ариунаа**  
Утас: 99092469 Цахим хаяг: [ariunaach@audit.gov.mn](mailto:ariunaach@audit.gov.mn)

**Аудитын менежер: Э.Энхцэцэг**  
Утас: 90077079 Цахим хаяг: [enkhtsetsege@audit.gov.mn](mailto:enkhtsetsege@audit.gov.mn)

**Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Уваа уул” аудит ХХК**  
Утас: 99108763 Цахим хаяг: [uwaauul.audit@gmail.com](mailto:uwaauul.audit@gmail.com)

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	3
2. Аудитын тайлан.....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	10
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	10
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	11
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3. Менежментийн захидал .....	12
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	17
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	20
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	22

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## 1. Аудитын гэрчилгээ

 <b>ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b> 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 Вэб сайт: dornogovi@audit.gov.mn	<b>АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР АНАГААХ УХААНЫ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ц.ЦАБШИР ТАНАА</b>
2020.02.28 № 1-6/133 танай _____ -ны № _____ -т	
<b>Аудитын гэрчилгээ</b>	
<p>Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
<b>Зөрчилгүй санал дүгнэлт</b>	
<p>Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
<b>Санал дүгнэлтийн үндэслэл</b>	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Ц.Цабшир танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 28-наас 2020 оны 2 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 23-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын захиалгаар “Уваа-уул аудит” ХХК –ийн захирал Ч.Мөнхтуяа, чанар хяналтын менежер А.Оюун, аудитор Ц.Мөнхтуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургууль нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 12 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд

аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь шинжлэх ухаан, технологийг эрчимтэй хөгжүүлж, судалгаанд суурилсан салбар их сургууль болон өргөжиж, өндөр ёс зүй, мэдлэг, мэргэжлийн ур чадвартай мэргэжилтнүүдийг бэлтгэн гаргахад оршино.

Тус сургууль нь БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1961 оны 431 дүгээр тогтоолоор анх байгуулагдаж, 1991 оноос салбар сургууль болон зохион байгуулагдсан бөгөөд Монгол Улсын Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн Удирдах зөвлөлийн 2014 оны 05 дугаар тогтоолоор Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургууль болгон нэрийг өөрчлөн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Боловсрол олгох үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын 2018 оны 80 дугаар тогтоолоор “Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол “Журам шинэчлэн батлах тухай”
- Төрийн албаны шинэчилсэн хуулийг дагаж гарсан эрх зүйн багц актууд болно. Тухайлбал Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол “Журам батлах тухай” (Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл олгох)

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургууль санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Ординат ХХК-ийн “Юникус” программ хангамж ашигладаг байна.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд эрсдэлтэй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 4 дүгээр улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1.0 хувийг сонгов.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.0 хувиар тооцсон нь эрсдэлийн түвшин “дунд” гэж үзсэнтэй холбоотой юм.

. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 14,299.4 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн үе шат болон нийт зардлын дүнтэй холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 104,050.3 мянган төгрөгөөр буюу 2,0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Сургалтын төлбөрийн авлага-Бакалавр	2,167,488.0	854,433.2	1,313,054.8	39,4
Оюутны байрны орлого	114,692.0	99,118.7	15,573.3	86,4
Дахин болон хичээл нөхөлтийн орлого	34,500.0	71,118,3	-36,618.3	206.1
Амралт сувиллын орлого	6,300.0	25,419.3	-19,119.3	403,5
Хүүгийн орлого	20,880.0	67,146.8	-46,266.7	321,6
Бусад орлого	21,960.0	58,302.2	-36,342.1	265,5
Хандив	0	500.0	-500.0	
Улсын төсвөөс санхүүжих	395,480.6	226,432.0	169,048.6	57,2
<b>Нийт дүн</b>	<b>2,761,300.6</b>	<b>1,402,470.5</b>	<b>1,358,830.1</b>	<b>50,8</b>

Авлага дансны үлдэгдэл өссөн нь төлбөртэй үйлчилгээний авлага буюу оюутнуудын сургалтын төлбөр төлөлтөөс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2018-2019 оны хичээлийн жилд үүссэн 545,921.8 мянган төгрөгийн, төв сургуулиас авах татаас санхүүжилтийн авлага 677,228.9 мянган төгрөгийн, байгууллагаас авах авлага 4,395.9 мянган төгрөгийн, хувь хүнээс авах 76.5 мянган төгрөгийн авлага байна. Үүнээс татаас санхүүжилтийн авлага буюу улсын төсвөөс авах тогтмол зардлын санхүүжилтийг олгохгүй байгаа шалтгааны улмаас барагдах эсэх нь тодорхойгүй, эрсдэлтэй 2015 оноос хойш үүссэн 677,228.9 мянган төгрөгийн авлага байна. Үүнтэй холбоотойгоор тус сургууль улсын төсвөөс авах тогтмол зардлын санхүүжилтийг өөрийн хөрөнгөөр төлж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тус сургууль сургалтад хэрэглэх нөөцөд байх шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн худалдаж авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь төсөвт тусгагдсаны тендер зарлаж оюутны дотуур байрны их засварыг хийж барилга байгууламжийн дансанд сайжруулалтаар, бага оврын автобусыг худалдан авч тээврийн хэрэгслийн дансанд бүртгэн авсантай холбоотой хөрөнгө оруулалтын 69,668.0 мянган төгрөг, хандиваар хүлээн авсан мянган төгрөгийн 1,160.0 хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлээгүй, акталсан болон данснаас хассан хөрөнгө байхгүй байна.

Биет бус хөрөнгийн бууралт 8,816.7 мянган төгрөг нь программ хангамжийн элэгдлийн дүн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь 2018 онд үүссэн түлш халаалт, цэвэр бохир усны өр 156,826.7 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжилт авч барагдуулах байсан боловч санхүүжилт олгогдохгүй байгаа тул байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахын тулд өөрийн хөрөнгөөр барагдуулсантай холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 2018-2019 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрийн урьдчилж орсон орлого 188,520.2 мянган төгрөгийг өглөгөөр бүртгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,956,099.7 мянган төгрөг болж 32,344.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 32,344.2 мянган төгрөг болсноос шалтгаалжээ.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургууль нь аж ахуйн тооцоон дээр ажилладаг, орлогоороо зарлагаа санхүүжүүлдэг бөгөөд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн захирлын 2019 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн А/07 тушаалаар орлогын төлөвлөгөөг 2,761,300.6 мянган төгрөгөөр, зарлагыг 1,987,618.6 мянган төгрөгөөр баталжээ.

Тайлант онд 2,761,300.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1,402,470.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 50,8 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Сургалтын төлбөрийн авлага-Бакалавр	2,167,488.0	852,902.6	1,314,585.3	39,3
Оюутны байрны орлого	114,692.0	99,118.7	15,573.3	86,4
Дахин болон хичээл нөхөлтийн орлого	34,500.0	72,648.9	-38,148.9	210,6
Амралт сувиллын орлого	6,300.0	25,419.3	-19,119.3	403,5
Хүүгийн орлого	20,880.0	67,146.8	-46,266.7	321,6
Бусад орлого	21,960.0	58,302.2	-36,342.1	265,5
Хандив	0	500.0	-500.0	
Улсын төсвөөс санхүүжих	395,480.6	226,432.0	169,048.6	57,2
<b>Нийт дүн</b>	<b>2,761,300.6</b>	<b>1,402,470.5</b>	<b>1,358,830.1</b>	<b>50,8</b>

Сургалтын төлбөрийн орлого нь 1,314,585.3 мянган төгрөгөөр тасарсан нь 2019-2020 оны хичээлийн жилийн элсэлт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй мөн жилийн чөлөө

авах, шилжих, сургуулиас гарах зэрэг шилжилт хөдөлгөөнөөс хамаарч оюутны тоо буурсантай холбоотой.

Оюутны байрны орлого нь 15,573.3 мянган төгрөгөөр тасарсан нь 2019-2020 оны хичээлийн жилийн элсэлт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй оюутны тоо буурсантай холбоотой.

Ийнхүү оюутны тоо элсэлтийн квотод хүрээгүй учир үндсэн бус үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлэх зорилго тавьж ажиллаж байна. 2019 онд үндсэн бус үйл ажиллагааны төлөвлөгөөг 140,377.0 мянган төгрөгөөр давуулж төвлөрүүлсэн. Энэ нь чөлөөт үлдэгдэлд тооцох банкны хүүгийн орлого, амралтын газрын орлого, дахин шалгалт хичээл нөхөлтийн орлого зэрэг нэмэгдсэнтэй холбоотой.

### Хүснэгт 3. Оюутны элсэлт, шилжилт хөдөлгөөний тоон үзүүлэлт

Огноо	2017 он	2018 он	2019 он
Шинээр элссэн оюутны тоо	140	137	91
Сургууль төгссөн оюутны тоо	173	163	138
Шилжилт хөдөлгөөн	30	38	45
Шилжиж ирсэн	5	7	14

Улсын төсвөөс санхүүжих орлого нь 169,048.6 мянган төгрөгөөр тасарсан нь их дээд сургуулиудад тогтмол зардлын санхүүжилтийг олгохгүй байгаагаас шалтгаалсан байна.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагааны хөтөлбөрт зориулан 1,987,618.6 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардлыг санхүүжүүлэхээр батлагдсан байна.

Нийт зардлын 395,480.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 2,365,820.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Орлого болон зарлагын зөрүүгээр 773,682.0 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан боловч гүйцэтгэлээр 1,402,470.6 мянган төгрөгийн орлого олж, 1,614,094.4 мянган төгрөгийн зардал гарч, эх үүсвэрийн дутагдал 211,623.8 төгрөгийн зардлыг дансны үлдэгдлээс санхүүжүүлсэн байна.

Эндээс харахад орлого, зардлын төлөвлөгөөний үндэслэлийг сайжруулах, орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар анхаарч цаашид ажиллах шаардлагатай байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,614,094.4 мянган төгрөг буюу 81,2 хувьтай байгаа нь үндсэн цалинг 2019 онд 10%-аар нэмэхээр төлөвлөн төсвийн төлөвлөгөөг батлуулсан боловч Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулиас цалинг нэмэхгүй байх шийдвэр гаргасан тул хойшлуулсан болно. Ингэснээр цалингийн сан 235,801.9 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 30,692.8 мянган төгрөгөөр хэмнэгдсэн.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын хувьд улсаас авах тогтмол зардлын санхүүжилт аваагүй боловч байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс 2018 оны 156,826.7 мянган төгрөгийн өрийг бүрэн төлж дуусгасан. 2019 онд зардлыг хэмнэж ажиллах зорилт тавин ажиллаж засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж ажилласан. Түлш халаалтын зардлыг хэмнэх үүднээс халаалтын тоолуурыг тавьсан, усны хэмнэлттэй технологи болох мэдрэгчтэй крантыг хичээлийн байр, дотуур байранд байршуулан, усны зөв зохистой хэрэглээг оюутнуудад хэвшүүлснээр байгууллагын усны хэрэглээг бууруулсан. Цахилгааны хэмнэлттэй технологи болох лед гэрлүүдийг хичээлийн байр, оюутны дотуур байранд байршуулсан зэргээс 15,678.6 мянган төгрөгөөр байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг хэмнэсэн байна.

Хангамж бараа материалын зардлыг 48,930,0 мянган төгрөгөөр хэмнэн ажилласан. Бичиг хэргийн зардлаас 6,008.4 мянган төгрөг, тээвэр шатахууны зардлаас 16,604.5 мянган төгрөг, шуудан холбооны зардлаас 4,950.7 мянган төгрөг, ном хэвлэл худалдан авах зардлаас 17,437.1 мянган төгрөгийг тус тус хэмнэсэн байна.

Урсгал засварт нийт 8,457.4 мянган төгрөг зарцуулсан.

Анагаах ухааны үндэсний их сургуулиас 2019 онд Дорноговь аймаг дахь салбар сургуульд 2 хөрөнгө оруулалтын 69,668.0 мянган төгрөгийн ажлыг эрх шилжүүлснийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна.

Бусад зардлын хувьд 2019 онд төлөвлөсөн зардлуудыг гарган төсвийн хэтрэлтгүй ажилласан байна.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургууль нь хэдийгээр орлогын төлөвлөгөөг тасалдуулсан боловч тус сургуулийн тогтмол зардлын санхүүжилтийг улсын төсвөөс олголтгүй он дамжсан татаас санхүүжилтийн авлагатай байгаа, оюутны элсэлтийн тоо цөөрснөөс шалтгаалсан үндсэн орлогын тасалдлыг үндсэн бус үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлэх замаар нөхөх арга хэмжээнүүдийг авч ажилласан, тогтмол зардлыг бууруулах, хэмнэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн зэрэг шалтгаан, үр дагаврыг харгалзан үзэж алдаа зөрчилд тооцоогүй болно.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 25 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 20 эрсдэл тодорхойлж нийт 13 горим сорил хэрэгжүүлээ.

Аудитаар нийт 18,237.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 6,000.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 12,237.8 мянган төгрөгийн зөрчилд алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Аудитаар дараах асуудлыг анхаарал татсан асуудлаар үзэж дараагийн аудит анхаарлаа хандуулах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

1. Тус сургуулийн тогтмол зардлын санхүүжилтийг улсын төсвөөс санхүүжүүлээгүй он дамжсан 677,228.9 мянган төгрөгийн авлагатай байна.
2. Орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангахад чиглэсэн арга хэмжээг хэрхэн зохион байгуулсан, орлогын буцаалт, хөнгөлөлтийг бүртгэлд тусгахдаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй хэрхэн уялдуулсан асуудал.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 109 мэдээллийг хугацаанд нь, 37 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

### **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага өгөөгүй бөгөөд нийт 8 зөвлөмж өгснөөс 8 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатанд буюу зөвлөмжийн хэрэгжилт 87,5 хувьтай байна.

### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 12,237.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тооцсон 14,299.4 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

#### **“Зөрчилгүй” дүгнэлт**

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

- 3.1.1. Илрүүлэлт Тус байгууллагын дансанд онлайн шинэ программ ашиглах болсонтой холбоотойгоор ашиглахаа больсон 4 программ бүртгэлтэй байв. Энэ нь “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 6 сарын 18-ны өдрийн 271 дүгээр тогтоолын 6.1, 6.2.1 заалтыг тус тус зөрчсөн, “Үнэн зөв ба үнэлгээ” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 3.1.2 Эрсдэл: Цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгийг данс бүртгэлд байлгаснаар хэрэглэгчдийг хөрөнгийн талаар буруу мэдээллээр хангаж байна.
- 3.1.3 Өгсөн зөвлөмж: Цаашид ашиглах боломгүй болсон программ хангамжуудыг холбогдох хууль, журмын дагуу данснаас хасах
- 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

#### 3.2 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

- 3.2.1 Илрүүлэлт: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар бүлгийг зөрчиж элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 219 үндсэн хөрөнгө ашиглагдаж байгаа нь “Үнэн зөв ба үнэлгээ” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 3.2.2 Эрсдэл: Санхүүгийн тайланд толилуулсан хөрөнгийн үнэ цэнэ буруу илэрхийлэгдэх, санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд буруу мэдээлэл өгөх үр дагавартай.

- 3.2.3 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах
- 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### **3.3 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал**

- 3.2.5 Илрүүлэлт: Оюутны дотуур байрны төлбөр, хичээл нөхөлтийн төлбөрийн орлогын буцаалтыг хийхдээ нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгит заасны дагуу бүртгэхгүй, тайлант үеийн зардалд бичсэн нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 18.2 заалтыг зөрчсөн “Үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 3.2.6 Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, тайлант үеийн зардлыг өсгөж, ашгийн хэмжээг бууруулах
- 3.2.7 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах
- 3.2.8 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2471841436.09</u></b>	<b><u>2317654402.88</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	1176918427.53	965294614.43
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	1176918427.53	965294614.43
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	1176918427.53	965294614.43
31213	Арилжааны банк дахь харилцах	1016827253.51	786113122.17
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	160091174.02	179181492.26
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1181040370.00	1227623191.33
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4365644.00	76500.33
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	488398650.00	545921795.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	688276076.00	681624896.00
3351	Байгууллагаас авах авлага	687076076.00	681624896.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1200000.00	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	113882638.56	124736597.12
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	4378261.83	2889076.62
35130	Эм боох материал	4378261.83	2889076.62
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	109504376.73	121847520.50
35410	Бичиг хэргийн материал	6741983.09	9291057.57
35420	Аж ахуйн материал	3365605.68	5400651.49
35430	Сэлбэг хэрэгсэл	211100.00	0.00
35440	Түлш, шатах тослох материал	167361.00	0.00
35450	Барилгын засварын материал	2572340.19	6447384.11
35460	Хүнсний материал	52750.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	96393236.77	100708427.33
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2776828960.05</u></b>	<b><u>2826965649.74</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2776828960.05	2826965649.74
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2331573626.58	2382270316.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	1937943378.90	1987741378.90
39202	Хуримтлагдсан элэгдэл	-53974531.43	-71667558.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	101928600.00	121798600.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-55256020.84	-58764473.23
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	277271792.92	281416792.92
39206	Хуримтлагдсан элэгдэл	-194331051.17	-203723558.25
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	567403772.17	580636772.17
39208	Хуримтлагдсан элэгдэл	-375124197.89	-386644349.34
39217	Ном	125711883.92	131476711.92
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	445255333.47	444695333.49
39301	Програм хангамж	14200000.00	14200000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-8256666.53	-8816666.51
39303	Бусад биет бус хөрөнгө	439312000.00	439312000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>5248670396.14</u></b>	<b><u>5144620052.62</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>324914868.00</u></b>	<b><u>188520295.00</u></b>

<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	324914868.00	188520295.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	156826711.00	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	156826711.00	0.00
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	168088157.00	188520295.00
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	168088157.00	188520295.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4923755528.14</b>	<b>4956099757.62</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	4923755528.14	4956099757.62
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1492195757.56	1492195757.56
51101	Өмч: - төрийн	1492195757.56	1492195757.56
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	99144499.38	131488728.86
51210	Өмнөх үеийн үр дүн	99144499.38	99144499.38
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	32344229.48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3332415271.20	3332415271.20
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>5248670396.14</b>	<b>5144620052.62</b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2013483614.61</b>	<b>1441504072.21</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1745420782.61</b>	<b>1215072072.21</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1735420782.61	1214572072.21
120002	Хүүгийн орлого	73179802.12	67146768.21
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1605125247.49	1058107941.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1427925325.00	890930295.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	177199922.49	166017646.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	1160000.00
120005	Түрээсийн орлого	4532000.00	8757200.00
120009	Бусад орлого	52583733.00	80560163.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	10000000.00	500000.00
122001	Хандив тусламж /дотоод/	10000000.00	500000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>268062832.00</b>	<b>226432000.00</b>
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	268062832.00	226432000.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	268062832.00	226432000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1748079050.49</b>	<b>1409159842.73</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1748079050.49</b>	<b>1409159842.73</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1734884998.49	1384497875.73
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	955262715.29	857361333.40
210101	Үндсэн цалин	768395052.31	701195266.75
210102	Нэмэгдэл	137944417.45	115279119.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41261296.53	37761351.53
210105	Гэрээт ажлын хөлс	7661949.00	3125596.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	113625454.38	107177360.25
210201	Тэтгэврийн даатгал	111436654.38	107132960.25

**Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн  
2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210202	Тэтгэмжийн даатгал	2188800.00	44400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	261562488.00	222990687.57
210301	Гэрэл, цахилгаан	14686277.00	21247034.00
210302	Түлш, халаалт	209923791.00	168924949.13
210303	Цэвэр, бохир ус	36952420.00	32818704.44
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	46037034.26	44622850.53
210401	Бичиг хэрэг	27760788.84	17036465.52
210402	Тээвэр, шатахуун	7490756.00	3629437.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8828782.89	8496817.76
210404	Ном, хэвлэл	0.00	181000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	111414.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1956706.53	15167716.25
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	15800206.17	17498221.29
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3385749.96	9262866.29
210502	Хоол, хүнс	2963295.00	5826355.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9451161.21	2409000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	70695571.85	14682403.38
210604	Урсгал засвар	70695571.85	14682403.38
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	33130734.00	30924365.00
210701	Гадаад албан томилолт	26964744.00	22050985.00
210702	Дотоод албан томилолт	6165990.00	8873380.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1615331.00	12542656.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1615331.00	5781600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	3000000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	285120.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	130936.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	77000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	3000000.00
210807	Газрын төлбөр	0.00	200000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	68000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	237155463.54	76697998.31
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3229206.00	497000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	64494309.25	33526860.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	169431948.29	42674138.31
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	13194052.00	24661967.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	13194052.00	19603367.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	400000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	2040992.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13194052.00	17162375.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	0.00	5058600.00
213501	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	5058600.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>265404564.12</b>	<b>32344229.48</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>265404564.12</b>	<b>32344229.48</b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1709265594.61</u></b>	<b><u>1402470568.11</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b><u>1674246016.61</u></b>	<b><u>1176038568.11</u></b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1664246016.61	1175538568.11
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	1660034016.61	1166781368.11
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1353590776.00	854433248.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	310655240.61	321105320.11
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	10000000.00	500000.00
122001	Хандив тусламж /дотоод/	10000000.00	500000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b><u>35019578.00</u></b>	<b><u>226432000.00</u></b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	32400000.00	226432000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	32400000.00	226432000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	2619578.00	0.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2619578.00	0.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1596051614.81</u></b>	<b><u>1544426381.21</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b><u>1596051614.81</u></b>	<b><u>1544426381.21</u></b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b><u>1582714162.81</u></b>	<b><u>1532015264.21</u></b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	961353097.27	861380435.46
210101	Үндсэн цалин	823203742.32	850656483.14
210102	Нэмэгдэл	110067153.92	4131831.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23336897.03	3585324.45
210105	Гэрээт ажлын хөлс	4745304.00	3006796.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	113061447.40	106455037.42
210201	Тэтгэврийн даатгал	113061447.40	106455037.42
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	111388130.00	379801998.57
210301	Гэрэл, цахилгаан	21338630.00	21247034.00
210302	Түлш, халаалт	90000000.00	288848740.13
210303	Цэвэр, бохир ус	49500.00	69706224.44
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	43406579.89	34077990.76
210401	Бичиг хэрэг	18361080.00	5807100.00
210402	Тээвэр, шатахуун	6139667.00	3462076.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8828782.89	8496817.76
210404	Ном, хэвлэл	7733100.00	5945828.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	111414.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2343950.00	10254755.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	9021980.00	15914890.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1033516.00	395890.00
210502	Хоол, хүнс	2820045.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5168419.00	15519000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	237880058.00	30603671.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	21295000.00	8564000.00
210602	Тавилга	63876303.00	13233000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	349261.00
210604	Урсгал засвар	152708755.00	8457410.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	33130734.00	30924365.00

210701	Гадаад албан томилолт	26852744.00	22050985.00
210702	Дотоод албан томилолт	6277990.00	8873380.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1615331.00	12461356.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1615331.00	5700300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	3000000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	285120.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	130936.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	77000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	3000000.00
210807	Газрын төлбөр	0.00	200000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	68000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	71856805.25	60395520.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10185234.25	13333991.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	61671571.00	47061529.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>13337452.00</b>	<b>12411117.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	13337452.00	12411117.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	2040992.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13337452.00	10370125.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>113213979.80</b>	<b>-141955813.10</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>0.00</b>	<b>69668000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>69668000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	0.00	69668000.00
221001	Их засвар	0.00	49798000.00
222001	Тоног төхөөрөмж	0.00	19870000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>0.00</b>	<b>-69668000.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	113213979.80	-211623813.10
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	1063704447.73	1176918427.53
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	1176918427.53	965294614.43

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	1,058,883,757.56	3,443,301,510.00	-139,549,559.25	4,362,635,708.31
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	433,312,000.00	-110,886,238.80	0.00	322,425,761.20
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,492,195,757.56</b>	<b>3,332,415,271.20</b>	<b>-139,549,559.25</b>	4,685,061,469.51
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн			238,694,058.63	238,694,058.63
<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,492,195,757.56</b>	<b>3,332,415,271.20</b>	<b>99,144,499.38</b>	4,923,755,528.14
<b>2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>1,492,195,757.56</b>	<b>3,332,415,271.20</b>	<b>337,838,558.01</b>	4,923,755,528.14
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,492,195,757.56</b>	<b>3,332,415,271.20</b>	<b>99,144,499.38</b>	4,923,755,528.14
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайлант үеийн үр дүн			32,344,229.48	32,344,229.48
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,492,195,757.56</b>	<b>3,332,415,271.20</b>	<b>131,488,728.86</b>	4,956,099,757.62

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1987618590.00	1614094381.21
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1987618590.00	1544426381.21
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1953177598.00	1532015264.21
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1097182348.00	861380435.46
210101	Үндсэн цалин	917182348.00	850656483.14
210102	Нэмэгдэл	11000000.00	4131831.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	55000000.00	3585324.45
210104	Урамшуулал		
210105	Гэрээт ажлын хөлс	15000000.00	3006796.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	137147793.00	106455037.42
210201	Тэтгэврийн даатгал	137147793.00	106455037.42
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	395480618.00	379801998.57
210301	Гэрэл, цахилгаан	33538909.00	21247034.00
210302	Түлш, халаалт	281825345.00	288848740.13
210303	Цэвэр, бохир ус	80116364.00	69706224.44
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	83008056.00	34077990.76
210401	Бичиг хэрэг	11815500.00	5807100.00
210402	Тээвэр, шатахуун	20066556.00	3462076.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13447500.00	8496817.76
210404	Ном, хэвлэл	23383000.00	5945828.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3824000.00	111414.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10471500.00	10254755.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	16563117.00	15914890.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1025117.00	395890.00
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	15538000.00	15519000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	44258015.00	30603671.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13045030.00	8564000.00
210602	Тавилга	22358440.00	13233000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	354545.00	349261.00
210604	Урсгал засвар	8500000.00	8457410.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	45521000.00	30924365.00
210701	Гадаад албан томилолт	22727000.00	22050985.00
210702	Дотоод албан томилолт	22794000.00	8873380.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	17165472.00	12461356.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6900000.00	5700300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3000000.00	3000000.00
210803	Даатгалын үйлчилгээ	480000.00	285120.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300000.00	130936.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110000.00	77000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5948000.00	3000000.00
210807	Газрын төлбөр	377472.00	200000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50000.00	68000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>116851179.00</b>	<b>60395520.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8890000.00	13333991.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	107961179.00	47061529.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>34440992.00</b>	<b>12411117.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>34440992.00</b>	<b>12411117.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2040992.00	2040992.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32400000.00	10370125.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.0</b>	<b>69668000.0</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>0.0</b>	<b>69668000.0</b>
221001	Их засвар	0.00	49798000.00
222001	Тоног төхөөрөмж	0.00	19870000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2761300618.00</b>	<b>1402470568.11</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>395480618.00</b>	<b>226432000.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	395480618.00	0.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	0.00	226432000.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>2365820000.00</b>	<b>1175538568.11</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2167488000.00	854433248.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	198332000.00	321105320.11
<b>122</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	<b>0.00</b>	<b>500000.00</b>
122001	Хандив тусламж /дотоод/	0.00	500000.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>1176918427.53</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>773682028.00</b>	<b>965294614.43</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>
610002	Төсвөөс гадуур байгууллага	1.0	1.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>112.00</b>	<b>86.00</b>
620001	Удирдах ажилтан	3.0	3.0
620002	Гүйцэтгэх ажилтан	67.0	49.0
620003	Үйлчлэх ажилтан	30.0	24.0
620004	Гэрээт ажилтан	12.0	10.0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>112.0</b>	<b>86.0</b>
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	65.00	48.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.00	1.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	34.00	27.00
650010	Гэрээт ажилтан	12.00	10.00

## 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2020-02-25			САГ-2020/161/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургууль		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Цаашид ашиглахгүй 4 программ хангамжийг данснаас хасаагүй байна.	7,700.0	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Ц.Цабшир А.Аззаяа
2	Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн "0" үлдэгдэлтэй үндсэн хөрөнгүүд ашиглагдаж байна.	0	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Ц.Цабшир А.Аззаяа
3	Дотуур байрны төлбөр, хичээл нөхөлтийн орлогын буцаалтыг зардалд бичсэн	4,537.8	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Ц.Цабшир А.Аззаяа